



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/630

Хэрлэн сум


Хэрлэн сумын Яслид
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын Яслийн гал тогооны тааз цууралт өгсөнтэй холбогдуулан засварын ажилд зориулж, 2,300,000 (хоёр сая гурван зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардлагатай хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ